



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн цахим бүртгэлийн
Health info 3 системийг эмнэлэг үйлчилгээнд
нэвтрүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 176 дахь заалт, Цахим эрүүл мэнд стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ НЬ:

Нэг. Эрүүл мэндийн мэдээлэл, бүртгэлийн тогтолцоог цахимжуулах эрүүл мэндийн цахим бүртгэлийн Health info 2 системийн шинэчлэгдсэн хувилбар Health info 3 систем гарсантай холбоотой Поликлиникт 2014 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс Стационарт 2015 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хоёр сарын туршилтын хугацаатайгаар нэвтрүүлж ажиллуулахыг Сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнхзаяа/, статистикч /О.Соёл-Эрдэнэ/, НЭМЭШСГХ-СМТА эрхэлсэн дэд захирал /В.Баярмаа/ нарт даалгасугай.


Хоёр. 2015 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс албан ёсоор үйл ажиллагаандаа ашиглаж хэвшүүлэхийг СЭМҮТ-ийн поликлиник, стационарын нийт эмч нарт үүрэг болгосугай.

Гурав. Эрүүл мэндийн цахим бүртгэлийн Health info 3 системийг эмнэлэг үйлчилгээнд нэвтрүүлэхтэй холбоотой сургалт явуулахыг Сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Г. Мөнхзаяа/-д даалгасугай.

00048

Дөрөв. Эрүүл мэндийн цахим бүртгэлийн Health info 3 системийг байнгын үйл ажиллагаатай болгож хэвшүүлэхийг Сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнхзаяа/, программист /П.Энхтуяа/, статистикч /О.Соёл-Эрдэнэ/, НЭМЭШСГХ-СМТА эрхэлсэн дэд захирал /В.Баярмаа/ нарт даалгасугай.

Тав. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг СТХНХ эрхэлсэн дэд захирал /О.Баатаржав/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  Л.НАСАНЦЭНГЭЛ